БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/90/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70642580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


Аудитын санал дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....14
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл .... 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .... 15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... 16
3.4 Материаллаг байдал .... 16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .... 16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.... 17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .... 18
3.8 Аудитын гол асуудал .... 18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.... 18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.... 19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.... 19
4. Аудитын илрүүлэлт ....19
4.1 Залруулсан алдаа.... 19
4.2 Төлбөрийн акт.... 19
4.3 Албан шаардлага .... 20
4.4 Зөвлөмж .... 20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## Аудитын санал дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 91

танай ________________ны № ________________т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ГАНХӨЛӨГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020151

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **202,007,436.48** | **192,330,007.48** |
| **33** | **АВЛАГА** | 20,756,425.00 | 25,884,676.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 12,457,175.00 | 15,737,726.00 |
| **335** | **Бусад авлага** | 8,299,250.00 | 10,146,950.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,299,250.00 | 10,146,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 181,251,011.48 | 155,945,331.48 |
| **351** | **Түүхий эд материал** | 88,411,284.29 | 88,411,284.29 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 88,411,284.29 | 88,411,284.29 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,057,727.19 | 67,534,047.19 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 142,500.00 | 197,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 76,263,908.00 | 62,525,428.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 1,160,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,651,319.19 | 3,651,319.19 |
| 35600 | Мал амьтад | 12,782,000.00 | - |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | 10,500,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | - | 10,500,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **734,713,137.73** | **704,243,672.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 734,713,137.73 | 704,243,672.26 |
| **392** | **Биет хөрөнгө** | 684,826,137.77 | 654,481,672.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 801,438,063.33 | 801,438,063.33 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (472,160,019.75) | (486,563,306.19) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 187,434,800.00 | 187,434,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (176,156,845.09) | (181,341,973.14) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 83,796,396.00 | 103,648,596.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (50,673,301.88) | (64,119,002.35) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,834,871.67 | 27,274,871.67 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,061,522.79) | (13,490,069.61) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 755,539,542.00 | 755,539,542.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (456,419,345.72) | (475,593,349.37) |
| 39217 | Ном | 253,500.00 | 253,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 49,886,999.96 | 49,761,999.92 |
| 39301 | Програм хангамж | 1,335,500.00 | 1,335,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (960,500.04) | (1,085,500.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,512,000.00 | 49,512,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **936,720,574.21** | **896,573,679.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **4,560,600.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 4,560,600.00 |
| **413** | **Өглөг** | - | 4,560,600.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 4,560,600.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 4,560,600.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **936,720,574.21** | **892,013,079.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 936,720,574.21 | 892,013,079.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 502,166,288.17 | 502,166,288.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 502,166,288.17 | 502,166,288.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 38,526,550.05 | (6,180,944.42) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 38,526,550.05 | 38,526,550.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (44,707,494.47) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 396,027,735.99 | 396,027,735.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **936,720,574.21** | **896,573,679.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **527,018,916.57** | **490,025,520.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **70,537,540.57** | **20,737,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 70,537,540.57 | 20,737,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 70,537,540.57 | 20,737,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 861,400.00 | 5,287,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 69,676,140.57 | 15,450,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **456,481,376.00** | **469,288,020.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 62,421,776.00 | 63,246,420.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,164,000.00 | 13,300,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,850,700.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,157,076.00 | 49,656,420.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 250,000.00 | 290,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 377,495,600.00 | 406,041,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 377,495,600.00 | 356,741,600.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | 49,300,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 16,564,000.00 | - |
| 133003 | Хөрөнгийн | 16,564,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **542,777,689.93** | **534,733,014.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **542,777,689.93** | **534,733,014.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 489,943,945.93 | 522,866,724.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,595,618.00 | 226,258,664.00 |
| 210101 | Үндсэн цалин | 148,585,622.00 | 158,747,201.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,495,247.00 | 54,464,170.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,514,749.00 | 13,047,293.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,844,804.00 | 29,128,628.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,586,773.00 | 20,390,332.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,936,068.00 | 2,253,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,930,963.00 | 1,722,519.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 399,180.00 | 441,826.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,991,820.00 | 4,320,903.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,799,570.00 | 41,003,126.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,898,570.00 | 7,289,501.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,901,000.00 | 33,713,625.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,713,225.00 | 15,077,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,948,345.00 | 2,139,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,221,910.00 | 9,231,320.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,542,970.00 | 1,706,830.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 180,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 180,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,683,740.00 | 30,400,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,000.00 | 440,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,670,740.00 | 29,960,940.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,667,000.00 | 3,911,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,667,000.00 | 3,911,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,894,144.00 | 3,270,068.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,883,470.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 323,279.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 172,650.00 | 329,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 342,960.00 | 347,535.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 120,000.00 | 120,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 51,064.00 | 50,254.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 202,565,844.93 | 173,816,848.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 86,255,667.00 | 117,315,683.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 100,000.00 | 1,739,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 116,210,177.93 | 54,761,665.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 52,833,744.00 | 11,866,290.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,752,750.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,758,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 993,850.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 33,080,994.00 | 10,866,290.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,080,994.00 | 10,866,290.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(15,758,773.36)** | **(44,707,494.47)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 55,343,644.02 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 55,343,644.02 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (55,343,644.02) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(71,102,417.38)** | **(44,707,494.47)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 502,166,288.17 | 396,027,735.99 | 109,878,967.43 | | 1,008,072,991.59 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн | - | - | - | | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **502,166,288.17** | **396,027,735.99** | **109,878,967.43** | **-** | 1,008,072,991.59 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (71,352,417.38) | | (71,352,417.38) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **502,166,288.17** | **396,027,735.99** | **38,526,550.05** | **-** | 936,720,574.21 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **502,166,288.17** | **396,027,735.99** | **38,526,550.05** | **-** | 936,720,574.21 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **502,166,288.17** | **396,027,735.99** | **38,526,550.05** | **-** | 936,720,574.21 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (44,707,494.47) | | (44,707,494.47) |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **502,166,288.17** | **396,027,735.99** | **(6,180,944.42)** | **-** | 892,013,079.74 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **443,984,276.00** | **487,032,695.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,692,400.00** | **5,287,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,692,400.00 | 5,287,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,692,400.00 | 5,287,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,692,400.00 | 5,287,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **442,291,876.00** | **481,745,195.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 64,796,276.00 | 75,703,595.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,164,000.00 | 13,300,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,850,700.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,157,076.00 | 62,113,595.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,624,500.00 | 290,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 377,495,600.00 | 406,041,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 377,495,600.00 | 356,741,600.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | 49,300,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **435,737,276.00** | **462,740,495.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **435,737,276.00** | **462,740,495.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **370,446,357.00** | **444,097,079.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,594,596.00 | 226,258,664.00 |
| 210101 | Үндсэн цалин | 148,584,600.00 | 158,747,201.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,495,247.00 | 54,464,170.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,514,749.00 | 13,047,293.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,845,826.00 | 29,128,628.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,587,795.00 | 20,390,332.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,936,068.00 | 2,253,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,930,963.00 | 1,722,519.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 399,180.00 | 441,826.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,991,820.00 | 4,320,903.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,799,570.00 | 41,003,126.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,898,570.00 | 7,289,501.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,901,000.00 | 33,713,625.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,599,080.00 | 14,763,230.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,834,200.00 | 1,825,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,221,910.00 | 9,230,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,542,970.00 | 1,706,830.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 533,900.00 | 554,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 533,900.00 | 554,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,924,090.00 | 18,693,660.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 440,000.00 |
| 210602 | Тавилга | 550,000.00 | 3,358,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,374,090.00 | 14,895,660.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,667,000.00 | 3,911,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,667,000.00 | 3,911,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,581,670.00 | 3,270,068.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,430,996.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 323,279.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 312,650.00 | 329,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 342,960.00 | 347,535.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 120,000.00 | 120,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 51,064.00 | 50,254.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 64,900,625.00 | 106,513,603.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,783,425.00 | 104,719,303.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 117,200.00 | 1,794,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,290,919.00** | **18,643,416.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,752,750.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,758,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 993,850.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 45,538,169.00 | 17,643,416.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,538,169.00 | 17,643,416.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,247,000.00** | **24,292,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,247,000.00** | **24,292,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,247,000.00** | **24,292,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,247,000.00 | 24,292,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 4,947,000.00 | 19,852,200.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,300,000.00 | 4,440,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(8,247,000.00)** | **(24,292,200.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 415,691,700.00 | 400,462,810.00 | 15,228,890.00 | 96.34 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 415,691,700.00 | 376,170,610.00 | 39,521,090.00 | 90.49 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 414,691,700.00 | 375,170,610.00 | 39,521,090.00 | 90.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231,683,100.00 | 226,258,664.00 | 5,424,436.00 | 97.66 |
| 210101 | Үндсэн цалин | 164,958,000.00 | 158,747,201.00 | 6,210,799.00 | 96.23 |
| 210102 | Нэмэгдэл | 53,225,100.00 | 54,464,170.00 | (1,239,070.00) | 102.33 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,500,000.00 | 13,047,293.00 | 452,707.00 | 96.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,277,500.00 | 29,128,628.00 | 2,148,872.00 | 93.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,010,100.00 | 20,390,332.00 | 1,619,768.00 | 92.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,948,700.00 | 2,253,048.00 | (304,348.00) | 115.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,221,700.00 | 1,722,519.00 | 499,181.00 | 77.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 463,400.00 | 441,826.00 | 21,574.00 | 95.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,633,600.00 | 4,320,903.00 | 312,697.00 | 93.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,876,400.00 | 41,003,126.00 | 2,873,274.00 | 93.45 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,914,800.00 | 7,289,501.00 | 625,299.00 | 92.10 |
| 210302 | Түлш, халаалт | 35,961,600.00 | 33,713,625.00 | 2,247,975.00 | 93.75 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,927,000.00 | 14,763,230.00 | 163,770.00 | 98.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,871,800.00 | 1,825,950.00 | 45,850.00 | 97.55 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,255,200.00 | 9,230,450.00 | 24,750.00 | 99.73 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,800,000.00 | 1,706,830.00 | 93,170.00 | 94.82 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 600,000.00 | 554,900.00 | 45,100.00 | 92.48 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | 554,900.00 | 45,100.00 | 92.48 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 43,472,000.00 | 18,693,660.00 | 24,778,340.00 | 43.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,500,000.00 | 440,000.00 | 20,060,000.00 | 2.15 |
| 210602 | Тавилга | 8,000,000.00 | 3,358,000.00 | 4,642,000.00 | 41.98 |
| 210604 | Урсгал засвар | 14,972,000.00 | 14,895,660.00 | 76,340.00 | 99.49 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,028,200.00 | 3,911,200.00 | 117,000.00 | 97.10 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,028,200.00 | 3,911,200.00 | 117,000.00 | 97.10 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,277,500.00 | 3,270,068.00 | 7,432.00 | 99.77 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 323,279.00 | 721.00 | 99.78 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333,200.00 | 329,000.00 | 4,200.00 | 98.74 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 348,100.00 | 347,535.00 | 565.00 | 99.84 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,000.00 | 120,000.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,100,000.00 | 2,100,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 52,200.00 | 50,254.00 | 1,946.00 | 96.27 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,550,000.00 | 37,587,134.00 | 3,962,866.00 | 90.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,750,000.00 | 35,792,834.00 | 3,957,166.00 | 90.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800,000.00 | 1,794,300.00 | 5,700.00 | 99.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **24,292,200.00** | (24,292,200.00) | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 24,292,200.00 | (24,292,200.00) | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 19,852,200.00 | (19,852,200.00) | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 4,440,000.00 | (4,440,000.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 366,391,600.00 | 362,029,100.00 | 4,362,500.00 | 98.81 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 362,441,600.00 | 356,741,600.00 | 5,700,000.00 | 98.43 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 362,441,600.00 | 356,741,600.00 | 5,700,000.00 | 98.43 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,950,000.00 | 5,287,500.00 | (1,337,500.00) | 133.86 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,950,000.00 | 5,287,500.00 | (1,337,500.00) | 133.86 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **64,796,276.00** | **68,926,469.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **64,796,276.00** | **68,926,469.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 52,339,101.00 | 68,926,469.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,454,196.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,454,196.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,884,905.00 | 68,926,469.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,884,905.00 | 68,926,469.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **12,457,175.00** | **-** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 12,457,175.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 64,796,276.00 | 75,703,595.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 64,796,276.00 | 75,703,595.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,164,000.00 | 13,300,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,350,700.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,688,436.00 | 62,113,595.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,593,140.00 | 290,000.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан

шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх эвсэг, чадварлаг, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн, орон нутгаа хөгжүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон хөгжлийн бодлого боловсруулан, хэрэгжүүлж иргэдийн итгэлийг хүлээсэн манлайлагч захиргааны байгууллага болох, тухайн ондоо оновчтой төлөвлөлт хийж, гүйцэтгэлийн үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлж, сум орон нутгийнхаа эдийн засаг,нийгмийн хөгжлийн тогтвортой ахиулах замаар иргэдийнхээ хөгжих боломжийг хангаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэн, төрийн үйлчилгээг стандартад нийцүүлэх чанартай хүргэнэ гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 598,121.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,971.8 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 6,280.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,146.8 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага бараа материал, үндсэн хөрөнгийн  данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | | | |
| **Авлага** | 20,756.4 | 25,884.6 | 5,128.2 |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 181,251.0 | 166,445.3 | -14,805.7 |
| **Үндсэн хөрөнгө** | 734,713.1 | 704,243.8 | -30,469.3 |
| **Нийт хөрөнгө** | 936,720.5 | 896,573.8 | -40,146.8 |
| **Өр төлбөр** | | 4,506.6 | 4,506.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 936,720.5 | 896,573.8 | -40,146.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 936,720.5 | 896,573.8 | -40,146.8 |

Авлага дансны үлдэгдэл 25,884.6 мянган төгрөг болж мянган 5,128.2 төгрөгөөр өссөн нь сумын өвс тэжээлийн иргэдийн авлага бүрэн барагдаагүйтэй холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2019-2021 онуудад үүссэн хувь хүнээс авах 10,146.9 мянган төгрөгийн авлага байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 166,445.3 мянган төгрөг болж мянган төгрөгөөр 14,805.7 буурсан нь эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 2020 оны орон нутгийн орлогын үлдэгдлийг ИТХ-аар батлуулан урсгал төсвийн худалдан авалтаар 24,292.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,560.6 мянган төгрөг болж өссөн нь Засгийн газраас төрөөс хариуцах цэвэр усны төлбөр дутуу санхүүжигдсэн нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 896,573.8 мянган төгрөг болж -40,146.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 36,993.4 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,044.6 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан нь 2021 онд Засгийн газраас хэмнэлтийн горим хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 480,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 64,308.00 мянган төгрөгөөр бууруулан 415,691.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 415,691.7 мянган төгрөгийн төсөв батлаcнаас 362,441.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 49,300.0 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс,

3,950.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 356,741.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,287.5 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 49,300.0 мянган төгрөг нийт 411,329.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 400,462.8 мянган төгрөгийг зарцуулж 10,866.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 802.2, ковид цар тахалтай тэмцэх иргэдийн хандив 3,000.0, Өвөрхангай аймгийн ЗДТГ-аас 10,000.0, аймгийн ЗДТГ-ын нөөц хөрөнгөөс 5,000.0, Булган Мээж ХХК-аас төрөөс хариуцах усны төлбөр 12,079.7, ХХААГ-аас үлийн цагаан оготно устгалын зардал 3,600.0, иргэдээс мал ээмэгжүүлэх хандив 300.0, ГХБХБГ-аас хүүхдийн хэрэгслийн дэмжлэг 500.0, аймгийн БХС-аас 27,374.4, аймгийн ИТХ-аас 300.0 мянган төгрөг нийт 68,926.5 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 62,149.4 мянган төгрөгийг зардалд зарцуулж 6,777.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 117 мэдээлэл оруулахаас 117 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа нь болоогүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн;
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,440.0, гар бөмбөгийн тэмцээнд 90.0, үзэсгэлэн худалдаанд 1,515.3 нийт 6,045.3 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй;
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 289,360.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 70,565.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 705.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлснээс НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах 1 зөвлөмж, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,961.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,385.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,898.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,177.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын зардлын дансны мал амьтад дансанд 10,500.0 мянган төгрөгийн ногоон тэжээл бүртгэж зардлыг ангиллыг буруу илэрхийлсэн алдааг залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 3,385.7 төгрөгийг холбогдох журамд нийцэхгүй зардалд зарцуулсан нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын

нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,440.0, гар бөмбөгийн тэмцээнд 90.0,үзэсгэлэн худалдаанд 1,515.3 нийт 6,045.3 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Цалингийн зардлаас цалингийн урьдчилгааг цалингийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 1,759.4 мянган төгрөгийг бичсэн дансны бичилтийн алдаа илэрсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Харилцагч байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын 4,094.1 мянган төгрөгийн баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/, харилцагч байгууллагуудаас 10 дээш гүйлгээ хийсэн харилцагч байгууллагуудыг түүвэрлэн тулгахад тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 заалтуудтай бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн зардалтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Засгийн газрын 2018 оны тогтоолыг зөрчин 2 орон тоог илүү баталж гүйцэтгэлээр 1 орон тоогоор дутуу буюу нийт 6177.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хишиг-Өндөр сумын ЗДТГ | 6 | 31,961.5 | 1 | 10,500.0 | 1 | 3,385.7 | 3 | 11,898.8 | 1 | 6,177.0 |